



МОНГОЛ ДААТГАЛ

2020

**ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

www.mongolmaatgal.mn



QR кодыг уншуулж нэгдээрэй

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эх орныхоо тайван амгалан, иргэдийнхээ тав тухтай амьдрал, Монгол улсынхаа хөгжлийн төлөө өдөр бүр зогсолтгүй ажиллаж байгаа эрхэм хэрэглэгч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе!

Монголын даатгалын салбарын үүсэл хөгжлийг эхлүүлсэн анхдагч компани “Монгол Даатгал” ХК-ийн хувьд өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээ бүхий 700 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон, цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож, судлан, байнгын сайжруулалтыг хийж, 2019 оны байдлаар бидэнд итгэл хүлээлгэсэн даатгуулагчдын тоо 255 мянгад хүрч, жилээс жилд нэмэгдэн, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна. Бид хөгжлөөрөө ямагт анхдагч, тэргүүлэгч байгааг хэлэхэд таатай байна. Түүнчлэн бид дэлхийд нэр хүндтэй, өндөр зэрэглэлтэй, тэргүүлэгч давхар даатгалын компаниудад эрсдэлээ шилжүүлснээр харилцагчиддаа давхар даатгагдсан хамгийн өндөр багцыг санал болгох боломжийг бүрдүүллээ.

Харилцагчидтайгаа хамтдаа хөгжүүлж буй бидний бизнес өдрөөс өдөрт өргөжин тэлж байгаа нь иргэд, байгууллагуудын даатгалын мөн чанар, ач холбогдлыг ойлгох ухамсар нэмэгдсэнтэй холбоотой. Гэсэн хэдий ч хүмүүний итгэлтэй ирээдүй, амар тайван амьдралын төлөө бидний итгэл үнэмшил цуцашгүй байж, даатгалын үйлчилгээг хялбар, ойлгомжтой, хүртээмжтэй хүргэхэд тэмүүлсээр байх болно.

ТҮҮХЭН ТОВЧОО

Монгол Даатгал ХК нь 1934 онд "Улсыг аюулаас хамгаалах газар" хэмээн Сангийн Яамны салбар нэгж болон тулгын чулуугаа тавьж үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй. Эдүгээ нэгэн наяны турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж, гадаад дотоодын түнш байгууллага, ард иргэддээ даатгалын үйлчилгээг тасралтгүй хөгжүүлэн хүргэж байгаа билээ.

2006

Монголд анх удаа 24/7 шуурхай дуудлагын албатай болов.

2010

hannover re
Олон улсын давхар даатгалын зах зээлийн томоохон давхар даатгагч болох "HANNOVER RE" компанитай хамтран ажиллаж эхэллээ.

2011

Даатгалын салбарт анх удаа өндөр хамгаалалттай олон улсын эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлэв.

2012

Банкашурансыг Монголд хөгжүүлэхээр дотоодын арилжааны банкуудтай хамтран ажиллаж эхлэв.



2014

Global Banking and Finance Review байгууллагаас Монгол улсын шилдэг Даатгалын компани -аар шалгаруулав.

2018

"Буухиа хүү" мобайл апплейшныг даатгалын салбарт анхлан гаргав.

ISO 9001:2015 ЧУТ-ны батламжаа хоёр дахь удаагаа баталгаажууллаа.

2017

ISO 9001:2015 ЧУТ-ны батламжаа баталгаажуулалтын гарчилгээгээ гардан авлаа.

2005

Дэлхийн банкны төслийн хүрээнд "Малын индексжүүлсэн даатгал" -ын борлуулагчаар ажиллаж эхлэв.

2003

Монгол Даатгал ХК хувьчлагдав.

1994

Монгол Даатгал ХК-ийн ажилтнууд оролцон боловсруулсан Даатгалын тухай Монгол улсын хууль хэлэлцэгдэн батлагдав.

1990

Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжив.

1974

ОУ-ын болон гадаадын байгууллагын барилга байгууламж, тээврийн хэрэгслийн заавал даатгалыг хийж эхэллээ.

1964

"Нэгдэл хоршооллын мал сүрэг, САА-н таримал ургамлын заавал даатгал" -ыг анхлан хийв.
ОУ-ын брокер болон давхар даатгагч нартай хамтран ажиллаж эхэллээ.

1962

Улсыг аюулаас хамгаалах газар нь Улсын даатгах газар нэртэй болж өөрчлөгдөв.

1961

ХАА-н нэгдлийн тариалангийн даатгал нэвтрүүлээ.

1934



Монгол Даатгал ХК-ийн суурь тавигдаж, анхны даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

1935

ЗХУ-ын Госотрах даатгалын газартай хамтран давхар даатгалын үйл ажиллагааг эхлүүлэв.

1936

"Албан байгууллага, аж ахуй нэгжийн даатгал" үйлчилгээг анх нэвтрүүлэв.

1946

Хувь хүн болон ажилтнуудад зориулсан амьдралын даатгалын бүтээгдэхүүн гаргав.

1947

"Тээврийн хариуцлагын заавал даатгал" хийж эхлэв.

1953

Зорчигчийн амь насны даатгал гаргав.

1949

Бөмбөгөр ногоон театрын хохирлыг барагдуулав



1959

Хоршооллын байгууллагын эд хөрөнгийн заавал даатгал нэвтрэв.

1949 он Бөмбөгөр ногоон театр нь Монгол Даатгал компанид даатгалтай байсан бөгөөд нийт 3 удаагийн гал гарч үүссэн хохирлыг тус тус нөхөн олгосон байна.




ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ 2020



ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ИЛҮҮ ХЯЛБАР, ИЛҮҮ ХУРДНААР

Та Facebook Messenger-ээр дамжуулан өөрт хэрэгтэй даатгалын үйлчилгээ болон мэдээлэл зөвлөгөө авах боломжтой.



"ГЭРЭГЭ КИОСК" АШИГЛАН

Та Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаа "Гэрэгэ" киоскоор дамжуулан ердөө л НЭГ МИНУТЫН ДОТОР даатгалаа хийлгэх болон сунгуулах боломжтой.

МОНГОЛ ДААТГАЛ БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН PEAK RE КОМПАНИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Монгол Улсад үйлчлэх эрүүл мэндийн даатгалын дотоодын бүтээгдэхүүний загвар, нөхцөл, хураамж тооцоолол зэргийг эцэслэн давхар даатгалын гэрээг үзэглэв.

- Андеррайтингийн журмыг ДД-тай хамтран боловсруулав.
- Компанийн борлуулалтын ажилтнуудад зориулсан дотоодын хэсэгчилсэн танилцуулга сургалт хийв.
- СЗХ-нд бүтээгдэхүүнийг бүртгүүлэхээр материалуудыг бэлтгэж хүргүүлэв.
- Цаашдын хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэсэг болох Хорт хавдар, хүнд өвчний эрсдлийн даатгалын яриа хэлэлцээг эхлүүлэв.



"ЯАРААД ЯАХАВ ДЭЭ" 2 АЯН

Аян 2 дахь жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд тус аян хэрэгжиж эхэлснээр улсын хэмжээний зам тээврийн ослын тоо буурсан бөгөөд тус аяныг дахиж явуулан үр дүн нэмэгдэж байна

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ 2020



МОНГОЛ ДААТГАЛ

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН
**ДАВХАР
ЁНДООТОЙ
ДААТГАЛ**

СУПЕР СУГАЛАА
Прюс 30

iPhone 11 Pro
LCD телевизор
Бензиний эрх

Сугалаанд хэрхэн оролцох вэ?
1-р тохирол Та газар дээр нь хусаад хож
2-р тохирол Супер 5 азтан 2020.12.20-нд тодорно

1800-1990
ДААТГАЛЫН ЛАВЛАХ

ДАВХАР ЁНДООТОЙ ДААТГАЛ

"Давхар ёндоотой даатгал" Тээврийн хэрэгслийн даатгал хийлгэсэн хүн бүрт сугалаа олгон газар дээр нь шатахууны эрх хожих эрх, 2020 оны жилийн эцэст нийт даатгуулсан даатгуулагчдын дундаас супер шагнал олгох зарчимтай үргэлжилж байна.



МОНГОЛ ДААТГАЛ

МАЛЫН
ИНДЕКСЖҮҮЛСЭН
ДААТГАЛ

СУГАЛАА
**Талын
Эрдэнэ**
УРАМШУУЛАГТ АЯН

СУПЕР

ХОНЖВОР:

1. Портер автомашин	1 АЗТАН
2. Мотоцикл	1 АЗТАН
3. Малчин иж бүрдэл	3 АЗТАН
4. LCD Телевизор	2 АЗТАН

ТОХИРОЛ: 2020.07.01-с өмнө сүүлийн 7 жилрт

ТАЛЫН ТАВАН ЭРДЭНЭ

Талын 5 эрдэнэ урамшууллын аян зохион байгуулж нийт орон даяар малын даатгал хийлгэж буй даатгуулагчдыг урамшуулсан.



МОНГОЛ ДААТГАЛ

УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН
**Бэлэгтэй
Даатгал
2020**

Унадаг дугуй
2ш

Хамгаалалтын хувцас
2ш

Аймаг бүрт 2 ширхэг унадаг дугуй,
2 ширхэг хамгаалалтын хувцас

Баяр наадмын талбай дээрээс
шууд тодруулна.

УРАЛДААНЧ ХҮҮХДИЙН БЭЛЭГТЭЙ ДААТГАЛ

Аймаг бүрт урамшууллын бараа унадаг дугуй 2ш хурдан морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас 2ш ийг өгч тус идэвхжүүлэлтийг дэмжих эрхийг салбарын удирдлагуудад өгч "Бэлэгтэй даатгал" урамшууллын аян зохион байгуулсан

БҮТЭЭГДЭХҮҮН & ҮЙЛЧИЛГЭЭ

Бид иргэд болон байгууллагуудад зориулсан Монгол дахь даатгалын бүх төрлийн үйлчилгээний хүрээнд 14 төрлийн, 70 гаруй үйлчилгээг иргэд, харилцагчдынхаа хүсэл хэрэгцээнд нийцүүлэн даатгалын хамгийн өргөн сүлжээгээр хүргэж байна.

ИРГЭДЭД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол,
эмчилгээний
даатгал



Хөрөнгийн
даатгал



Автотээврийн
хэрэгслийн
даатгал



Хүртээмжтэй
даатгал



Мал, амьтдын
даатгал



Жолоочийн
хариуцлагын
даатгал

БАЙГУУЛЛАГАД ЗОРИУЛСАН ДААТГАЛЫН ХЭЛБЭРҮҮД



Гэнэтийн осол,
эмчилгээний
даатгал



Хөрөнгийн
даатгал



Автотээврийн
хэрэгслийн
даатгал



Хариуцлагын
даатгал



Газар
тариалангийн
даатгал



Агаарын
хөлгийн
даатгал



Ачааны
даатгал



Барилга
угсралтын
даатгал



Санхүүгийн
даатгал



Итгэлцлийн
даатгал



Агаарын хөлгийг
өмчлөх эзэмших
ашиглахтай холбоотой
хариуцлагын даатгал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн одоогийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 03 сарын 05-ны өдрийн ээлжит хурлаар тогтоов.



ГРОМОВ С.Б.

ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд
ТУЗ-ийн дарга



ОГАЙ Н.Ю.

ТУЗ-ийн ердийн гишүүн



Л.ТАНЯ

ТУЗ-ийн ердийн гишүүн



Ч.ЭНХ-АМГАЛАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
"Монгол Даатгал" ХК-ийн
Гүйцэтгэх захирал



Т.БААСАНЖАВ

ТУЗ-ийн ердийн гишүүн
"Монгол Даатгал" ХК-ийн
Даатгалын газрын захирал



О.ЭРДЭНЭБУЛГАН

ТУЗ-ийн ердийн гишүүн
"Монгол Даатгал" ХК-ийн
Үйл ажиллагаа хариуцсан газрын захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



О.ЦОГТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
"Хүлэг консалтинг ТМЗ" ХХК
Татварын зөвлөх



Ц.ОЮУНЖАРГАЛ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Глобал стратеги удирдлагын институт
Гүйцэтгэх захирал



Д.ОТГОНБАТ

ТУЗ-ийн хараат бус гишүүн
"Обзерв" консалтинг ЗҮБ
Ерөнхий захирал

УДИРДЛАГЫН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Ч.ЭНХ-АМГАЛАН

Гүйцэтгэх захирал

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр, /БНСУ/ Хандонг Глобал их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэг, Мөн МУИС-ийн Хууль зүйн сургууль - Эрх зүйч мэргэжлээр, Гүрэн дээд сургууль Төрийн удирдлагын магистр зэрэг, МУИС-ийн Бизнесийн сургууль докторант зэрэг тус тус мэргэжил эзэмшсэн. Санхүү, Даатгалын салбарт 18 дахь жилдээ удирдах албан тушаал эрхэлж байна.



Т.БААСАНЖАВ

Даатгалын газрын захирал

Япон улсын Кобэ их сургуулийг Эдийн засагч (Хөгжлийн эдийн засаг) мэргэжлээр, Хитоцубаши их сургуулийг эдийн засагч (Эконометрикс) мэргэжлээр тус тус Магистр зэрэг хамгаалсан. АНУ-ын Рочистерийн их сургуулийг эдийн засагч (Механизм дизайн) мэргэжлээр Магистрын зэрэг хамгаалсан. Санхүү, Даатгалын салбарт 6 жил удирдах албан тушаал эрхэлсэн.



Н.БАТБАЯР

Санхүүгийн удирдлагын газрын захирал

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Нягтлан бодогч мэргэжлээр дүүргэсэн. Тус салбарт эдийн засагч, санхүү удирдлагын албан тушаалд 9 гаруй жил ажилласан туршлагатай.




О.ЭРДЭНЭБУЛГАН

Үйл ажиллагаа хариуцсан газрын захирал

ШУТИС-ийн КТМС-ийг Санхүүгийн менежмент мэргэжлээр бакалавр болон магистр зэрэг хамгаалсан. Мөн Гүрэн дээд сургуулийг Төрийн захиргааны менежмент мэргэжлээр мастер зэрэгтэй дүүргэсэн. Монголын болон Олон улсын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжүүдэд Гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны захирал албан тушаалуудад амжилттай ажилласан 17 жилийн удирдахуйн туршлагатай.

ХҮНИЙ НӨӨЦ


Манай компани өөрийн өргөн мэдээллийн бааз суурь, тогтвортой соёл, мэргэшсэн чадварлаг баг хамт олонд тулгуурлан Монгол улсын 21 аймаг дахь өөрийн 33 салбар, даатгалын борлуулалтын хамгийн өргөн сүлжээгээр бүхий 700 гаруй төлөөлөгчөөрөө дамжуулан харилцагч төвтэй даатгалын үйлчилгээг санал болгон ажиллаж байна. Үйлчилгээний хүртээмжээ нэмэгдүүлэн орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглан цахимаар даатгалын үйлчилгээг хүргэн, тэдний хүсэл, хэрэгцээ, сэтгэл ханамжийг 7/24 цагаар зогсолтгүй сонсож, судлан, байнгын сайжруулалтыг хийж, санхүүгийн голлох үзүүлэлтээр тэргүүлж байна.




Монгол орныг хамарсан ДААТГАЛЫН ӨРГӨН СҮЛЖЭЭ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН


ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ
ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР




Нийт хураамжийн орлого




Цэвэр хураамж




Нийт нөхөн төлбөр



Нийт нөөцийн сан




Нийт хөрөнгө




ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТҮҮД:	2018Q4	2019Q4	2020Q2
			<i>/төгрөг/</i>
НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО	30,408,043,292	32,658,573,403	12,247,676,527
НИЙТ НӨХӨН ТӨЛБӨР	8,578,969,283	17,868,071,348	4,277,477,543
НИЙТ ХӨРӨНГӨ	37,552,237,037	43,293,617,143	37,648,986,528
НӨӨЦИЙН САН	22,661,050,164	24,353,846,068	21,131,706,002
ДААТГАЛЫН ЦЭВЭР ХУРААМЖ	21,374,514,984	21,536,251,648	10,012,331,809

ХУРААМЖ



НИЙТ ХӨРӨНГӨ



Аудитлагдсан

БАЛАНС	2019Q4	2020Q2
		<i>/сая төгрөг/</i>
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	33,759	28,228
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	9,535	9,421
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	43,294	37,649
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,297	2,757
ОРЛОГОД ТООЦООГУЙ ХУРААМЖИЙН НӨӨЦ	15,039	12,002
ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН	13,643	13,760
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	43,294	37,649

ОРЛОГЫН ТАЙЛАН	2019Q4	2020Q2
		<i>/төгрөг/</i>
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО	32,658,573,403	12,247,676,527
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ	322,836,483	176,200,323
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ	33,895,159	116,902,245

2020 оны тайлант хугацаанд Монгол Даатгал ХК нь амжилтаа бататган, зах зээлд тэргүүлэгч байр сууриа хэвээр хадгалан, дараах амжилтуудыг үзүүллээ.


ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Даатгал ХК-ийн төлбөр чадварын үзүүлэлт нь 2020 оны II улирлын байдлаар 120 хувьтай байгаа нь даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлээд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй, төлбөрийн чадвар нь зохистой түвшинд хангагдсан болохыг илэрхийлж байна.


ҮЗҮҮЛЭЛТ	2017 Q4	2018 Q4	2019 Q4	2020 Q2
Төлбөрийн чадварын харьцаа Solvency	122%	110%	111%	120%
Хохирлын харьцаа Loss ratio	56.4%	44.4%	46.9%	42.1%
Зардлын харьцаа Expense ratio	46.0%	62.2%	70.4%	67%
Хосолсон харьцаа Combined ratio	102.4%	106.6%	116.9%	108.9%

ХУВЬЦААНЫ АРИЛЖАА 2020

Хаалтын ханш




Арилжигдсан ширхэг



Хаалтын ханш: 1,500.00
Нийт хувьцааны тоо ширхэг: 64,132,321

НИЙТ ХУРААМЖИЙН ОРЛОГО

СУВАГ	ГҮЙЦЭТГЭЛ	ХУВЬ
БАНК	319	32%
ЗУУЧЛАГЧ	286	29%
ТӨЛӨӨЛӨГЧ	333	30%
ШУУД БОРЛУУЛАЛТ	304	33%
УЛААНБААТАР ХОТЫН САЛБАР	2313	35%
ОРОН НУТГИЙН САЛБАР	2783	44%
БАЙГУУЛЛАГЫН ДААТГАЛ	5910	80%
НИЙТ ДҮН	12,247	70%



Хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр

- 20301 Автотээврийн хэрэгслийн даатгал
- 30333 Жолоочийн заавал даатгал
- 20101 Үл хөдлөх хөрөнгийн даатгал
- 20108 Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал
- 10101 Гэнэтийн ослын даатгал
- Бусад

ДАВХАР ДААТГАЛЫН ТҮНШҮҮД

ДАВХАР ДААТГАЛ

Бид хүлээн авсан эрсдэлээ үнэлэн, шинжилгээ хийж, өөрийн төлбөрийн чадвар, эдийн засгийн чадавх, макро эдийн засгийн өөрчлөлт, хандлагатай уялдуулан дэлхийн томоохон, нэр хүндтэй давхар даатгагч нарт эрсдэлийн багцаа Трити болон факультатив байдлаар нэг бүрчлэн давхар даатгуулдаг.

Бид давхар даатгагчдын санхүүгийн найдвартай байдлыг нэн түрүүнд чухалчлан, санхүүгийн хүчин чадлын үнэлгээгээр A.M.Best "A-", S&P "BBB"-ээс дээш үнэлгээтэй нэр хүнд бүхий зах зээлд тэргүүлэгч давхар даатгагчаар даатгуулдаг.


Манай факультатив давхар даатгалын эрсдэлийг Их Британи, Герман, Сингапур, Хон-Конг, Оросын холбооны улсад байрласан санхүүгийн хүчин чадлын зэрэглэл тогтоогч Standard & Poor's, A.M.Best, Fitch-ийн өндөр үнэлгээ бүхий давхар даатгалын компаниуд хүлээн авдаг.

Дэлхийд нэр хүндтэй, өндөр үнэлгээтэй, томоохон давхар даатгагч нар нь манай эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэхээс гадна, харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт болон түргэн шуурхай үйлчилгээ авах боломжоор хангаж байгаа юм.

Давхар даатгах нөхцөлүүд:

- 12,5 сая ам.доллар хүртэлх үнэлгээтэй даатгалын гэрээний даатгалын гэрээний дагуу автоматаар хамгаалалтад багтана.
- Багцын давхар даатгалын хамгаалалтаас давсан өндөр үнэлгээ бүхий эсвэл онцгой төрлийн үйл ажиллагаа явуулдаг харилцагчидтай факультатив давхар даатгалын гэрээг байгуулна.
- Олон улсын эрүүл мэнд, гадаад зорчигчдын гэнэтийн ослын даатгалын үйлчилгээг дэлхийн нэр хүндтэй, даатгалын зах зээлд тэргүүлэгч давхар даатгалын компаниуд MAPFRE ASSISTANCE болон Allianz Worldwide Care-тай хамтран харилцагч нартаа хүргэж байна.

Бид хүлээн авсан эрсдэл бүртээ шинжилгээ хийж шаардлагатай тохиолдолд давхар даатгалын хамгаалалтаар бүрэн хангаж харилцагчдынхаа найдвартай түнш байх зорилгоо тогтмол биелүүлсээр байна.



АЛСЫН ХАРАА

Даатгалын иж бүрэн үйлчилгээг айл өрх, албан байгууллага
бүрт хүргэсэн дэлхийн жишиг компани байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид харилцагч төвтэй, мэргэшсэн, ёс зүйтэй даатгалын
үйлчилгээг шилдэг шийдлээр хүртээмжтэй хүргэж итгэлтэй
ирээдүйг бүтээлцэнэ.

Дэлхийн Даатгалыг Монголоос...